

"Бүх нийт боловсролын төлөө"
Иргэний нийгмийн үндэсний эвсэл



НАЙЗЫГ МИНЬ СУРГУУЛЬД ОРУУЛ

(Төсөлт ажлын удирдамж)





НАЙЗЫГ МИНЬ СУРГУУЛЬД ОРУУЛ!

(Төсөлт ажлын удирдамж)

Улаанбаатар хот
2024 он

Боловсруулсан

Я.Мөнхчимэг

Б.Батчимэг

Редактор

Д.Тунгалаг

Боловсролын төлөө чанга дуугар! төслийн санхүүжилтээр хэвлэв

УДИРТГАЛ

“Найзыг минь сургуульд ОРУУЛ!” төсөлт ажил нь олон улсад 2005 онд анх зохион байгуулагдаж, сургуулийн гадна үлдсэн хүүхэд бүрд чанартай, үнэ төлбөргүй боловсрол олгох шаардлагыг улс орны Засгийн газар, дэлхийн удирдагчдад тавьж ТББ, хүүхэд, багш нар, эцэг эхчүүд, Үйлдэрчний эвлэлүүд зэрэг 115 улс орны 5 сая гаруй хүн дуу хоолойгоо нэгтгэж оролцсон юм. Сүүлийн 17 жилийн турш Англи улсад сургуулиуд болон залуучуудын оролцон зохион байгуулж байгаа төсөлт ажил дайн, хямрал мөргөлдөөн, байгалийн гамшигт өртсөнөөс сургуульд явж чадахгүй байгаа сая сая хүүхдэд туслахыг парламентийн гишүүддээ уриалж, Английн засгийн газрын боловсролын бодлогод нөлөөлөхийг чармайж байна.

Энэ удаа Монгол улсад сургууль, багш нар, сурагчид Боловсрол эвсэлтэй хамтран сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг эдлүүлэхийн төлөө хүчтэй дуу хоолой гаргах боломж олдож байна.

“Найзыг минь сургуульд ОРУУЛ!” төсөлт ажил нь сурагчдад сэтгэлзүйн, ёс суртахууны болон нийгэм-соёлын мэдлэг, ойлголт, хандлагыг хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан авах томоохон боломж байхаар бид төлөвлөсөн юм. Тухайлбал,

- ✓ Төсөлт ажлын явцад өөрсдийн бүтээлч санаа, уран сэтгэмжээ хөгжүүлэн үзэл бодлоо илэрхийлэхэд суралцана (сэтгэлзүйн хөгжил)
- ✓ Хүний эрхэд суурилсан боловсролын асуудлуудыг судалснаараа ёс зүйн үнэт зүйл төлөвшүүлнэ (ёс суртахууны хөгжил)
- ✓ Хамтдаа нэгдэн нэг зорилгын төлөө төсөлт ажилд нэгдэн, үйл ажиллагаа зохион байгуулна (нийгмийн хөгжил)
- ✓ Залуус, сурагчид Ерөнхий сайд, УИХ-ын гишүүдэд нөлөөлөхийг оролдсоноороо ардчилалд суралцана. (нийгмийн хөгжил)
- ✓ Залуус, сурагчид тэгш хамруулах соёл, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, олон улсын хөдөлгөөний нэг хэсэг болно. (соёлын хөгжил)

Уг төсөлт ажлаар дамжуулан сургуулийн нийгмийн ажилтан, түүх, нийгмийн ухааны багш нар, анги удирдсан багш нар сурагчдадаа “Дэлхийн иргэний боловсрол”-ын агуулгыг олгохоос гадна уг багцыг хэрэглэгдэхүүн болгон сургууль дахь эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэн, хамтран ажиллах бүрэн боломжтой.

ШҮҮМЖИТ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ “АСУУДЛЫН МОД” ЗАГВАР ХИЧЭЭЛ



МЭДЭЭЛЭЛ

Дэлхий даяар сургуулийн гадна 250 сая хүүхэд байгаа бөгөөд нэмэгдээд хэдэн сая хүүхэд сургуулиас гарах эрсдэлтэй байна¹. ЮНЕСКО-гийн судалгаагаар сургуульд сурсан нэг жил нь алсдаа хувь хүний орлогыг 10 хувиар өсгөдөг² болох нь нотлогдсон.

Тиймээс сургуулийн гадна байгаа хүүхдүүд рүү чиглэсэн үе тэнгийхнийг нь оролцуулсан оролцоот төсөлт ажил нь тэднийг сургуульд ирэхэд, бодлого шийдвэр гаргагчдыг энэ асуудалд анхаарал хандуулахад тустай юм. Сургуульд элсэн суралцаж чадахгүй байгаа, суралцсан ч дундаас нь завсардаж боловсрол эзэмших боломжгүй хүүхдүүдэд тулгарч буй саад тотгоруудыг илрүүлэх, түүний учир шалтгааныг олох, авч хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлоход багш, сурагчдад дэмжлэг болох зорилготой уг багц нь ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдад эрх тэгш байдлын талаар мэдлэг ойлголт өгч, шүүмжит сэтгэлгээг хөгжүүлэн, тодорхой үйлдэл хийх зэргээр дэлхийн иргэний боловсрол, ардчиллын боловсрол болон тогтвортой хөгжлийн боловсролыг олгоход чиглэж байна.

ЕБС-ийн сурагчдад төсөлт ажлаар дамжуулан асуудлыг шийдвэрлэх, шүүн тунгаах, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх зэрэг зөөлөн ур чадваруудыг хөгжүүлэхэд уг төсөлт ажил тусална хэмээн найдаж байна.

Төсөлт ажлын загвар

МЭД! Сургуулийн гадна байгаа болон сургууль завсардсан хүүхдийн тухай, боловсролын ач холбогдлын талаар мэдэж авна.

ТУНГАА! Хүүхдүүд яагаад сургуульд орж чадахгүй байгаа болон сургуульд явж байснаа гарч байгаа шалтгаан нөхцөлийн талаар бодно. Тухайн хүүхдүүдийн оронд өөрийгөө тавьж үзнэ. Асуудлын шийдлийг хамтаараа бодож олно.

ҮЙЛД! Гарсан шийдлүүдээ өөрийн орон нутгаас сонгогдсон болон боловсрол, нийгмийн асуудлаар идэвхтэй ажилладаг гишүүдэд захиа бичнэ

1 UNESCO UIS, 2023

2 GEM report 2016, UNESCO

Гол арга зүй

АСУУДЛЫН МОД

(Та бүхэн загварын дагуу ажиллаад гаргасан шийдлээ Ерөнхий сайд, өөрийн амьдардаг тойргоос сонгогдсон эсвэл боловсрол, хүүхдийн эрхийн чиглэлээр идэвхтэй ажилладаг УИХ-ын гишүүнд илгээгээрэй)

Яагаад дэлхий дээр бүх хүүхэд сургуульд явж чадахгүй байна вэ? Сургуульд явахад нь тэдэнд тулгардаг саад бэрхшээлүүд, учирдаг сорилтуудыг хэн, хэрхэн шийдэх ёстой вэ?

Тулгарч буй асуудал бүр шийдэх шийдэлтэй, гарах арга замтай байдаг. Эдгээр шийдлүүд, гарах арга замуудыг хууль тогтоогчид буюу УИХ, хууль хэрэгжүүлэгчид буюу Засгийн газар, Боловсролын яам боловсруулж, хүүхэд нэг бүрийн сайн сайхны төлөө ажилладаг.

Асуудлын мод нь тодорхой асуудлын учир шалтгаан, шийдлүүд дээр төвлөрч ажиллах төгс арга юм. Сурагчид асуудлын модыг өөр өөрсдийнхөөрөө бүтээж, өөрсдийн гаргасан санаануудаа хамтдаа ярилцах боломж олгоно. Энэхүү дасгал ажил нь хичээлийн зохион байгуулалтын хувьд уян хатан байж болохоор боловсруулагдсан бөгөөд анхан, дунд, ахисан шатны үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн боломжтой.



АНХАН ШАТ

(хичээлийн 1 цаг дээр зохион байгуулах боломжтой)

Сэдэв: НАЙЗЫГ МИНЬ СУРГУУЛЬД ОРУУЛ!!

Шийдэх асуудал “Дэлхий дээр зарим хүүхэд яагаад сургуульд явж чадахгүй байна вэ?”

Үйл явц: Энэ асуудлыг шийдэх шийдэл байгаа юу?

Үр дүн: Сурагчид хичээлийн төгсгөлд багшаас өгсөн удирдамжийн дагуу бодлого тодорхойлогч (Засгийн Газар, Боловсролын яам), шийдвэр гаргагчдад (УИХ-ын гишүүн) хүүхэд нэг бүрийг сургуульд явуулах нь яагаад чухал гэж үзэж байгаа талаараа захидал бичиж илгээнэ.

Хэрэглэгдэхүүн:

Тойм мэдээлэл, үзүүлэх материал, тохиолдол шинжлэх



1. Үзүүлэх материал
2. Олон улсын тохиолдол шинжлэх
3. Өөрийн орны тохиолдол шинжлэх



ЭВИДЭНС,

14 настай, Зимбабве улс

Зимбабве бол 15.7 сая хүн амтай Өмнөд Африкт орших улс юм. Нийслэл нь Хараре. Зимбабве нь үзэсгэлэнтэй газар нутагтай бөгөөд улаан буудай, эрдэнэ шиш, үр тариаг бусад улс орнуудад борлуулахын тулд ихээр тарьдаг. Уур амьсгалын өөрчлөлт Зимбабвегийн цаг агаарт нөлөөлж, байгалийн гамшиг, үер, ган гачиг их хэмжээгээр хүнсний ногоо тариалахад хүндрэл учруулж байна. Энэ нь тус улсын хүн амын бараг тал хувь нь өлсгөлөнд нэрвэгдэхэд нөлөөлсөн. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй үер, шуурга, ган болон бусад байгалийн гамшиг нь Зимбабве зэрэг дэлхийн олон орны хүмүүсийн амьдралд шууд нөлөөлж байна. Жишээлбэл, хоёр жилийн өмнө Хараред хүчтэй шуурганы улмаас сургуулийн барилга нурж ашиглах ямар ч боломжгүй болжээ. Тиймээс Эвидэнс болон түүний найзууд сургууль завсарджээ. Энэ хугацаанд Эвидэнс гэртээ байж газар тариалангийн ажилд туслалцахын хажуугаар дүү нараа хардаг байв. Тэр үргэлжлүүлэн сурах эсэхдээ санаа зовох чөлөө завгүй өдөр хоногуудыг өнгөрүүлсэн юм.

Эвидэнсийн сургуулийн барилгыг олон улсын байгууллагын санхүүжилтээр шинээр барьж, гамшигийн үед илүү тэсвэртэй бат бөх барилгатай болсноор сургууль дахин үүд хаалгаа нээсэн.

Эвидэнсийн хувьд хичээлээсээ төсөөрсөн учир сургуульдаа үргэлжлүүлэн сурч чадах эсэхдээ эргэлзэж айдастай байв. Харин хичээлдээ явсан эхний өдрөөс эхлэн сургуулийн зүгээс хоёр жилийн хоцрогдлыг нь нөхөх хөтөлбөр хэрэгжиж багш нар нь хоцрогдсон агуулгуудыг зааж эхлэв. Эвидэнс



*Evidence's class practise disaster risk reduction
Photo: Save the Children
Evidence and Diowd's names have been changed*

бага багаар буцаж сурагчийн амьдралын хэмнэлдээ дасаж цаашид үргэлжлүүлэн суралцах хүсэл тэмүүлэл дүүрэн болсон. Эвидэнс сайн боловсрол эзэмшсэнээр ирээдүйд хүссэнээрээ сайхан амьдарч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож хэвийн амьдралаа үргэлжлүүлэх боломжтой болох юм байна гэдгийг ухаарсан учир хичээнгүйлэн суралцаж байгаа тухайгаа хуваалцсан.

Эвидэнсийн хоцрогдлыг нөхөхийн төлөө ажиллаж байгаа багш Диов хоцрогдлыг нөхөх нь ямар чухал болохыг тайлбарлав. Эвидэнсийн багш Диов **“хүүхэд бүрийн сурах явц, арга барил ялгаатай учир тэдэнд тохиромжтой аргаар заах маш чухал. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас олон гамшиг тохиолдож байгаа, цаашид ч тохиолдсоор байх учир энэ хугацаанд боловсролын үйлчилгээг тасалдалгүй байхад анхаарах хэрэгтэй”** гэдгийг онцолсон юм.

РОМАНА,

7 настай, Мьянмар\Бангладеш

Бангладеш бол 169 сая хүн амтай Азийн өмнөд хэсэгт оршдог улс. Нийслэл нь Дакар хот. Бангладештай хиллэдэг хөрш Мьянмар улсын үндэстний цөөнхийг Рохинжа гэдэг. Рохинжачууд Мьянмарт олон жилийн турш дарамт, хүчирхийлэлд өртөж ирсэн. 2017 онд, Мьянмар дахь аймшигт хүчирхийллийн дараа 700,000 Рохинжачууд (тэдний талаас илүү нь хүүхдүүд) Бангладешд дүрвэн ирсэн байна. Бангладеш руу дүрвэсэн Рохинжа хүүхдүүдийн ихэнх нь зургаан жилийн турш сурах сургуульгүй болсон.

Романа бол 7 настай охин бөгөөд эцэг эх, дүүгийнхээ хамт амьдардаг. Тэрээр 2 настай байхдаа гэр бүлийнхээ хамт Мьянмараас гарч, Рохинжагийн дүрвэгсдийн хуаранд суурьшжээ. Романа тархины саажилттай бөгөөд энэ нь түүний хөдөлгөөн, тэнцвэрт байдалд нь нөлөөлдөг гэсэн үг юм.

Романаг дүрвэгсдийн хуаранд анх ирэхэд өдөр бүр хийх ажил нь түүнд маш хэцүү байсан бөгөөд гэр бүлийнхэн нь шинэ орчинд дасан зохицохоос гадна түүнд нийгэм, бие бялдар, боловсролын талаар нэмэлт дэмжлэг хэрэгтэй байдал тул санаа зовж байв. Жишээлбэл, Романаг алхах төхөөрөмжөөр хангах хэрэгтэй бөгөөд түүний хэл ярианы чадварт нь туслах зорилгоор тогтмол сургалтанд хамруулдаг.

Романагийн гэртээ авч байгаа дэмжлэг нь удахгүй хуаранд суурилсан сургалтын төвд сурч буй бусад хүүхдүүдтэй нэгдэх боломжтой болгоно гэсэн үг. Романагийн ганцаарчилсан дэмжлэгийн төлөвлөгөө нь түүнийг хэдхэн долоо хоногийн дотор уншиж, бичиж сурахад нь маш их хувь нэмэр болсон. Романагийн ээж Рафика охиныхоо боловсролыг үргэлж анхаарч, эмчилгээтэй зэрэгцүүлэн гэрийн боловсрол олгодог. Тэрээр **“Би хэзээ ч**



photo: Humanity & Inclusion Romana and Rafika's names have been changes

итгэл найдвараа алддаггүй. Охин маань хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа ч боловсрол эзэмших бүрэн эрхтэй” гэжээ. Гэсэн хэдий ч дэмжлэгийн “Тэгш хамруулах сургалтын” багийн тусламжтайгаар Романа гэрээр боловсролын хөтөлбөрт хамрагдаж, физик эмчилгээ, хэл ярианы эмчилгээ болон бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр дамжуулан боловсролоо үргэлжлүүлэн дээшлүүлэхэд боломжтой болсон.

Гэрт суурилсан сургалтыг нэмэлт дэмжлэгтэй хослуулсан энэхүү арга зүй нь Романаг ирээдүйд ердийн сургуульд сурч, амжилтанд хүрэхэд шаардлагатай бэлтгэл болох юм. Мөн эдгээр сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах боловсролд хандах хандлагыг өөрчлөх, сургалтын төвийг бүх хүүхдэд хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Тэгш хамруулсан боловсрол”-ын чиглэлээр багш нарыг бэлтгэж байна.

ВИОЛО,

16 настай, Өмнөд Судан

Өмнөд Судан бол 10.7 сая хүн амтай Зүүн Африкийн улс юм. Нийслэл нь Жуба. Тус улс нь бэлчээрээр баялаг, халуун орны ой мод, намагтай бөгөөд шинээр байгуулагдсан орнуудын нэг. Учир нь Өмнөд Судан 2011 онд зэвсэгт мөргөлдөөний дараа л тусгаар тогтносон улс болсон. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэл үргэлжилсээр. Олон хүмүүс гэр орноо орхин дүрвэж, олон гэр бүл, хүүхдүүд хөрш Уганда улсад амар амгалан амьдарч болох газар хайсан хэвээр байна.

Африкийн улс орнуудад уур амьсгалын өөрчлөлт ургац болон цэвэр усны хүртээмжид хамгийн түрүүнд нөлөөлдөг. Үр дагаварт нь олон хүн өлсгөлөнд нэрвэгдэж, итгэл найдвараа алдаж, тэжээллэг хоол хүнс, цэвэр ус хэрэглэх боломжгүй болохын зэрэгцээ гэр бүлийн хүчирхийлэл, охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллэл нэмэгддэг. Ковид19 цар тахал Өмнөд Суданы охидын нөхцөл байдлыг улам дордуулсан. Хөл хорионы үед, сургуулиуд хаагдаж, охид хөвгүүдээс илүү олноор сургуульдаа явахаяа больсон. Хөл хорионы дараа сургууль дахин нээгдсэн ч маш олон охид сургуульдаа буцаж ороогүй юм. Виола бол 16 настай охин бөгөөд хөл хорионы үеэр сургууль завсардсан боловч хөл хорионы дараа сургуульдаа буцаж явах боломжтой болсон. Тэрээр хэлэхдээ, **“Хөл хориотой үед би ихэнх цагаа ээжтэйгээ нүүрс, элсэн чихэр зарж өнгөрөөсөн. Би радиогоор явж байсан хичээлд оролцохыг оролдсон боловч энэ нь надад тус болоогүй. Миний түвшинд тохирох нэвтрүүлэг хэзээ нь гарч байгааг би олж чадаагүй. Надад сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй байсан. Гэхдээ сургууль дахин нээгдэх үед би сургуульдаа буцаж явж чадна гэдэгт найдаж байсан. Тэгээд би одоо буцаж ирсэндээ маш их баяртай байна, учир нь би**



Photo: Mustafa Osman/Oxfam

сурч, өөртөө гэрэлт ирээдүйг бүтээхийг хүсч байна. Харамсалтай нь, манай ангийн ихэнх хүүхдүүд хөл хорионы дараа сургуульдаа буцаж ирээгүй. Охидын зарим нь сургууль хаагдсан үед жирэмсэн болсон, зарим нь гэр бүлтэй болсон эсвэл өөр шалтгаанаар гэртээ үлдэхээс өөр аргагүй болсон. Ийм байдлаар коронавирус охидод хөвгүүдээс илүүтэй нөлөөлсөн. Хэрэв бид жирэмсэн болвол сургуульдаа буцаж чадахгүй, хөвгүүдэд бол энэ хамаагүй.”

Сургуулиа амжилттай төгсөж буй охид, залуу эхчүүдэд анхаарлаа хандуулах зорилготой түргэвчилсэн сургалтын хөтөлбөрт хамрагдсанаар Виола сургуульдаа эргэн орох боломжтой болсон юм. Хөтөлбөр нь боловсролд тасалдал үүссэн боловсрол нь тасалдсан охидтой ажиллах багш нарыг сургаж, охидын сурах хэрэгцээ, сайн сайхан байдлыг хангах үүднээс сургуулийн тогтсон цагийн хуваарийг өөрчилсөн байна. Виолагийн оролцсон хөтөлбөр амжилттай болсон ч Өмнөд Судан, Уганда улсын 22 сургуульд л хэрэгжсэн. Хичээлдээ хоцорсон хүүхдүүдэд энэ мэт түргэвчилсэн сургалтын хөтөлбөрүүд дэлхий даяар шаардлагатай байдаг. Энэ хөтөлбөрүүдийн үр шимийг хүртэх бүх хүүхдийн хэрэгцээг хангахын тулд олон хөтөлбөрийг шинээр бий болгох хэрэгтэй.

ЖЕНСОН,

10 настай, Их Британи, Умарт Ирландын Нэгдсэн Вант улс

Их Британи бол 67.3 сая хүн амтай Баруун Европын улс юм. Нийслэл нь Лондон хот. Энэ нь Англи, Шотланд, Уэльс, Хойд Ирланд гэсэн дөрвөн үндэстнээс бүрддэг.

Их Британи бол дэлхийн хамгийн баян улсуудын нэг боловч сүүлийн үед бусад орнуудад чиглэсэн уур амьсгалын өөрчлөлт, ядуурал, боловсрол, зэвсэгт мөргөлдөөн зэрэг дэлхийн сорилтуудыг бууруулахад санхүүжилт өгдөг хэмжээгээ бууруулжээ.

Их Британи даяар хэдэн арван мянган хүүхдүүд “Найзыг минь сургуульд оруул!” нэртэй хөдөлгөөнд оролцдог. Тэд үүгээрээ дамжуулан дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүүхэд бүрийн сургуульд сурч, чанартай боловсрол эзэмших эрхийг Их Британийн Засгийн газраас дэмжихдээ ямар хэмжээ авч болох талаар суралцдаг байна.

Женсон 10 настай бөгөөд Эссекс дэх бага сургуулийн ангийнхан болон багштайгаа уг төсөлт ажилд оролцсон. Энэ нь Женсонд, Их Британийн парламент дахь орон нутгийн төлөөлөгч нь Жеймс Слеверли бөгөөд Их Британи Умард Ирландын Нэгдсэн вант улсын гадаад хэргийн сайд ба энэхүү ажлынхаа хүрээнд олон улс оронтой хамтран ажилладаг гэдгийг мэдэж авахад тусалжээ.

“Найзыг минь сургуульд оруул!” төсөлт ажлын хүрээнд Женсон болон түүний ангийнхан уур амьсгалын өөрчлөлт, зөрчил мөргөлдөөн зэрэг хямралд нэрвэгдсэн сая сая хүүхдүүд сургуульд явахад ямар бэрхшээл тулгардаг талаар мэдэж авсан. Женсон болон түүний ангийнхан Их Британи улс яагаад бусад улс орнууд болон дэлхийн хүүхдүүдийн боловсролыг дэмжих ёстой талаар ярилцахын тулд Парламентын гишүүн Жеймс Слеверли рүү захидал бичихээр шийдэж түүнийг сургуульдаа хүрэлцэн ирэхийг урьсан байна.



Children at Jenson's school hand James Cleverly their messages Photo: Rebekah Lucking /Send My Friend to School

Жеймс Слеверлитэй уулзах үеэрээ Женсон өөрийн захидлыг уншиж танилцуулсан. **“Бид хүүхэд бүр боловсрол эзэмших эрхтэй гэж боддог. Хөгжлийн бэрхшээл, байгалийн гамшиг, дайн, ядуурал гэх мэт хүүхдүүдийг сургуульд явахыг зогсоодог шалтгааныг хүүхдүүд өөрсдөө сонгоогүй юм. Тиймээс та бидний санаачлагыг бусад хамтран зүгтгэгч нартаа танилцуулж сонсож, хүүхдүүдийг сургуульд явуулахын төлөө ажиллахыг уриалаарай.”**

Жеймс Слеверлид сурагчдын захидлууд маш их сэтгэгдэл төрүүлсэн бөгөөд тэрээр Засгийн газрын бусад хүмүүстэй хуваалцахаа амлав. Энэхүү айлчлал нь ихээхэн шуугиан тарьж, олон нийтийн сүлжээ болон орон нутгийн сонинд мэдээллүүдээ түгээн цацагдсан. Дараа долоо хоногт болсон боловсролын талаарх хэлэлцүүлгийн үеэр өөр нэг парламентын гишүүн Женсоны захиаг уншиж, арга хэмжээ авахыг уриалав.

Хүүхдүүд өөрчлөлт хийж чадна гэдгээ мэдэх нь чухал. Нэг хүүхдийн нэг захидал, уриалга, мессаж Засгийн газарт том нөлөө үзүүлж чадна. Женсон Их Британийн хүүхдүүдтэй хамт бусад орны хүүхдүүдэд сургуульд суралцахад нь, боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж, өөрсдийн хувь нэмрээ оруулсан юм.

Өөрчлөлт шинэчлэлтийг уриалсан дэлхийн дэлхийн улс орон даяар илгээсэн олон мянган захидлууд, мессежүүд дэлхийн удирдагчдад хэрхэн нөлөөлснийг бодоод үз дээ.

Тохиолдол шинжилнэ үү.

“

“Хичээлээ таслаад явахад нь уяачтай хүртэл холбогдож байгаад хүүхдээ буцааж ирүүлдэг. Нэг хүүхдийн аав нь байна гэж ирээд худлаа яриад аваад явчихсан байсан. Ээж рүү нь утасдаад асуухаар манай хүүхэд гэртээ ирээгүй гэж хэлсэн болохоор цагдаагийн байгууллагад мэдэгдсэн чинь бидэнд саад боллоо, ална хядна гэж сүрдүүлэх тохиолдол ч гарч байсан.

Уяачид уралдааныг эд хөрөнгөө арвижуулах нэг боломж гэж ойлгодог учраас ямар нэгэн байдлаар саад болохоор бухимддаг. Унаач хүүхдүүдийг байнга авч явах хандлагатай байдаг. Өвөл ч гэсэн



мориныхоо ажлыг хийдэг юм билээ. Манай аймгийн урдуур том том блокон хашаатай, тойроод жүчээнүүд нь байдаг. Уяачид хүүхдүүдээр морины уяа тойлготой ажлыг өвөл гэхгүй хийлгүүлж, үндсэн ажилтан мэт ханддаг”

Сургуулийн нийгмийн ажилтантай хийсэн ярилцлагын хэсгээс


“

“Намайг У гэдэг, би 21 настай. Одоо нөхөр, хүүхдийн хамт амьдардаг. Бүрэн дунд боловсролтой. Дунд анги хүртэл суралцсан. Суралцаж байх хугацаанд намайг жирэмсэн гэдгийг мэдээд ангийнхан болон сургуулийн хүүхдүүд янз бүрээр хэлж байсан.

Жирэмсэн байх хугацаанд сургуулийн нийгмийн ажилтантай харилцаж байгаагүй. Хүүхдүүд янз бүрээр хэлж шоолохоос гадна би өөрөө маш их ядардаг байсан. Намайг жирэмсэн гэдгийг багш нар мэдээд маш их загнаж, хичээл дээр “Та нар тэр У-г хар. Одоо ингээд л хүүхдээрээ шахуу хүүхэдтэй болоод амьдралгүй болно” гэх мэтээр жишээ болгож ярьдаг байсан. Нөхөртэйгөө хамт амьдардаг болохоор нөхөр ажилдаа явахаар хүүхэд харах хүнгүй учир үргэлжлүүлж сурах боломжгүй. ЕБС-д сурч байх хугацаанд надад дэмжлэг байгаагүй”

Боловсрол эвслийн кейс судалгаанаас

Тохиолдол шинжилнэ үү.



“


“Сургуульд суралцдаг гацдаг, муу ярьдаг хүүхдэд ангид нь дохионы орчуулагч байдаггүй. Гэрийхэнтэйгээ бага зэрэг ойлголцдог ч гадны хүмүүс болон үеийнхээ хүүхдүүдтэй холбоо үүсгэж чаддаггүй. Ямар нэг харилцан яриа үүсгэдэггүй. Дохионы багш байхгүй учир бусад хүүхэд, багш нар түүнтэй харьцах боломжгүй”³

Эцэг эхчүүдтэй хийсэн ярилцлагын хэсгээс

“

Сургууль завсардсан сурагчдын шалтгааныг багш нараас асуухад дараах хариулт өгсөн. Үүнд: гэртээ хичээл хийх ширээгүй, даалгавраа хийх боломж олддоггүй; хичээлийн хэрэглэгдэхүүнгүй; ажил хийх зорилгоор; эцэг эх, асран хамгаалагч нь сургуульд сургах сонирхолгүй, ар гэрийн анхаарал сул учраас; эцэг эх, асран хамгаалагч нь архины хамааралтай; дүү нараа харах, өвчтэй эцэг эхээ асрах, тэжээн тэтгэдэг; гэр нь сургуулиас алслагдмал; мал малладаг учир, хурдны морь унадаг; хувцас хунар муутайгаас анги ахих тусам бусдаасаа ичих нэрэлхдэг; үе тэнгийн хүүхдүүдийн гадуурхал, дарамт, дээрэлхэлт гэх мэт

2021 оны Боловсрол эвслийн судалгаанаас



“

“Д нь 4 билүү 5 настайдаа аав ээж хоёр нь салаад манайд ирсэн. Одоо 7 жил болж байгаа. Ирснээсээ хойш ээжийгээ хараагүй учир царайг нь мартчихсан байх.

Сургуульд оруулах гээд ээжээс нь бичиг баримтыг авах гэсэн боловч өгөөгүй. Хүүхдийн мөнгийг нь авах гээд өгөхгүй байгаа гэж бодож байна. Аав нь манай хамаатан ч орон гэргүй айл, айл дамжин амьдардаг. Би 2019 онд сумын хүүхэд хамгааллын багт хүсэлт тавьж түр асран хамгаалагч нь болсон. Албан бус боловсролын төвд явуулж дөрвөн аргын тоо, уншиж бичиж сургана гэж бодож байгаа. Цаашдаа малчин л болох байх”

2020 онд хийсэн Боловсрол эвслийн судалгааны үеэрх ярилцлагаас

³ “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгаа, М.Батбаатар, Боловсрол эвсэл, 2020 он.

ДУНД ШАТ

(Хичээлийн 2-3 цагт зохион байгуулах боломжтой)

Сэдэв: НАЙЗЫГ МИНЬ СУРГУУЛЬД ОРУУЛ!

Шийдэх асуудал “Сургуульд суралцаж чадахгүй байгаа хүүхдүүдийг хэрхэн сургуульд явуулах вэ?”


Үйл явц: Сурагчид багшийн өгсөн мэдээлэлтэй танилцан хосоороо ярилцах, багаар хэлэлцэх аргуудыг ашиглан учир шалтгаан буюу “Асуудлын мод”-ны үндсийг бий болгож бичнэ.

Дараа нь сурагчид “хэрвээ сурагчид сургуульд суралцаж боловсрол эзэмшихгүй бол” ямар үр дүн гарч ирж болох талаар эргэцүүлнэ. Эргэцүүлэлээ өөр хоорондоо ярилцан зурсан “Асуудлын мод” дээрээ бичиж модоо бүрэн бүтэн болгоорой.

Хамгийн сүүлд нь хэрэгжих, шийдэгдэх боломжтой шийдлүүдийг сонгож аваад үр жимс болгон бичээрэй.

Анхаарах нь: Зөв болон буруу хариулт гэж байхгүй. Энэхүү үйл ажиллагааны зорилго нь сурагчдыг “Асуудлын мод”-ны загварыг ашиглан эргэцүүлэл хийлгэн бодуулж, өөрсдийн үзэл бодол, санааг өөр хоорондоо ярилцах, бодлого шийдвэр гаргагч нарт хүргэхэд чиглүүлэхэд оршино.

Үр дүн: Асуудлын мод дээр ажилласан ажил нь шийдвэр гаргагч нарт хүргэх суурь мессеж болох юм. Энэ нь хувь хүний юм уу бүлгийн мессеж байж болно. Сурагчид хичээлийн төгсгөлд багшаас өгсөн удирдамжийн дагуу бодлого тодорхойлогч (Засгийн Газар, Боловсролын яам), шийдвэр гаргагчдад (УИХ-ын гишүүн) хүүхэд нэг бүрийг сургуульд явуулах нь яагаад чухал гэж үзэж байгаа талаараа захидал бичиж илгээнэ.



Хэрэглэгдэхүүн:

Сурагчид кейс, судалгаа, ППТ ашиглан учир шалгааныг бодож олно. “Асуудлын мод”-ны

1. Учир шалтгаан,
2. Үр дүн,
3. Шийдэл хоорондоо логик холбоотой байна.

АХИСАН ШАТ

(Хичээлийн 3 дээш цагт зохион байгуулах боломжтой)

А ХУВИЛБАР АСУУДЛЫН МОД” ЗАГВАР

- Сурагчид ганцаараа болон багаараа ажилласан “Асуудлын мод”-оо самбарын цаасан дээр хэвлэнэ (зурна). Үндэс, эх бие, мөчир жимснүүдтэй л бол “Асуудлын мод”-оо ямар харагдах бол гэдэгт битгий санаа зовоорой.
- Модныхоо голд “Найзыг минь сургуульд ОРУУЛ” гэж томоор бичнэ.
- Сурагчид судалгаа, ППТ, хэлэлцүүлгээ ашиглан тодорхой бүлгийн хүүхдүүд боловсрол хамрагдахгүй байгаа шалтгаануудыг тодорхойлон үндсэн 5 сэдэв сонгон авна.
- Дараа нь сурагчид сургууль завсардалттай холбоотой ямар үр дагаврууд үүсэхийг багаараа ярилцана. Эдгээр үр дагавруудаа мөчир дээр бичээрэй. Асуудлын модоо өнгөөр ялган будаарай.
- Сүүлд нь асуудлыг шийдэх боломжтой шийдлүүдийн талаар ярилцаарай. Сурагчид шийдлээ жимсэн дээр бичнэ.

Анхаарах нь: Зөв болон буруу хариулт гэж байхгүй. Энэхүү үйл ажиллагааны зорилго нь сурагчдыг “Асуудлын мод”-ны загварыг ашиглан Тогтвортой хөгжлийн зорилго 4: Хэнийг ч ардаа үл үлдээх чанартай боловсрол зорилгын хэрэгжүүлэхэд тулгамдаад буй асуудуудын талаар шүүмжлэлтэй эргэцүүлэн бодуулж өөрсдийн санааг хоорондоо ярилцах, бодлого шийдвэр гаргагч нарт хүргэх арга замуудыг олж үйлдэл хийхэд чиглүүлэх юм.

Үрдүн: Асуудлын мод дээр ажилласан ажил нь шийдвэр гаргагч нарт хүргэх суурь мессеж болох юм. Энэ нь хувь хүний юм уу бүлгийн мессеж байж болно. Сурагчид хичээлийн төгсгөлд багшаас өгсөн удирдамжийн дагуу бодлого тодорхойлогч (Засгийн Газар, Боловсролын яам), шийдвэр гаргагчдад (УИХ-ын гишүүн) хүүхэд нэг бүрийг сургуульд явуулах нь яагаад чухал гэж үзэж байгаа талаараа захидал бичиж илгээнэ.

Хэрэглэгдэхүүн:

“Асуудлын мод”-ны хайчилбарууд, хайч, цавуу

УЧИР ШАЛТГААН (ҮНДЭС)

Засгийн газар сургуулиудын төсвийг нэмээгүй

Боловсролын тогтолцооны асуудал

Асран хамгаалагчдын анхаарал халамж сул


Цар тахлын үед олон улс орон боловсролын салбарын төсвөөс танаж эрүүл мэнд, нийгмийн халамжид зарцуулсан

Сургуулийн ээлгүй соёл

Багш нар тэгш хамруулан сургах боловсролын талаар бэлтгэгдээгүй

Хүмүүсийн хэвшмэл ойлголт, нийгмийн шахалт (охид, хөвгүүдийн үүрэг)

Цахим хичээл заахад сургалтын хөтөлбөр, арга зүй, багшийн бэлтгэл хангалтгүй



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулахад дэд бүтцээс эхлээд алхам тутам асуудалтай тулгардаг

Ихэнх сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургахад бэлэн биш,

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамгийн ихээр боловсролоос гадуурхагдаж байгаа

Цар тахлын үед хичээлд хамрагдах нь хүнд сорилт болж байсан





Ялгаварлан гадуурхалт

Техник тоног төхөөрөмж, дэд бүтэц цахим хичээлд бэлэн биш байсан

Ядуурал

Ялгаатай байдлын талаар ойлголтгүй



ҮР ДҮН (МӨЧИР)

Манай сургууль сурагчдаас саван вок, анги засвар гэх мэт зэрэг нэмэлт мөнгө хураадаг

Сургууль, хороо, бүртгэлийн ажилтнууд хоорондоо уялдаагүй нэгдсэн мэдээллийн бааз байхгүй тул сургууль завсардалсан хүүхдийн тоо мэдээлэл дутмаг

Үс засалт, өмссөн хувцаснаас болж сургууль руу оруулдаггүй

Бага дунд орлоготой улсуудад амьдардаг ХӨБ хүүхдүүдийн тал нь сургуульд явдаггүй

Хөвгүүд ажил хийж мөнгө олох хэрэгтэй тул сургууль завсарддаг

ТВ хичээл үзэхэд хэт хурдан заадаг учир ойлгож амждаггүй

Сургуулийн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцсонгүй гээд багшид байнга загнуулж хичээлдээ явахаас залхдаг

Охид гэрээ цэвэрлэж, дүүгээ харах ёстой болохоор хичээлдээ явдаггүй

Манай суманд интернэт байдаггүй, байсан ч компьютер тог байх эсэхийг мэдэхгүй тул цахим хичээл хийх асуудал хүнд

Бага дунд орлоготой улсуудад амьдардаг ХӨБ охидын 1/3 нь л сургуулиа төгсдөг

Үндэсний цөөнх сурагчдад зориулсан хос хэлний хөтөлбөр байхгүй эх хэл дээрх ном, хичээл заах багш дутагдалтай

Хичээл хийхэд нь асран хамгаалагчидын дэмжлэг байхгүйгээс хоцрогдол үүсдэг

Сургуулийн удирдлага жирэмсэн болсон охидыг сургуулиас хөөдөг

Дэлхий дээр 258 сая сурагчид сургуульд явдаггүй



ШИЙДЭЛ (ҮР ЖИМС)

Бүх улсууд боловсролын салбартаа илүү хөрөнгө оруулах хэрэгтэй

Бага ангиас эхлэн дэлхийн иргэний боловсролыг сургалтын хөтөлбөрт оруулах

Тэгш хамран сургахад тохирох хэрэглэгдэхүүнүүдээр хангах

Ялгаатай хэрэгцээнд тохирсон бодлогын дэмжлэг байх хэрэгтэй

Сайн бэлтгэгдсэн багш anti-sexism, тэгш байдлын тухай сурагчдадаа зааж чадна

Багш ХӨБ -тэй ажиллахад хэрэгтэй сургалт, нөөцөөр тасралтгүй хангагдах ёстой

Багш нарыг ажилдаа тогтвортой байхад сайн сургалт, нөөц, материал хэрэгтэй

Сургуулийн буруу соёлыг халах (хөвгүүд үсээ ургуулж болохгүй, охид юбка өмсөх ёстой гэх мэт)

Эцэг эхийн боловсрол дээшлүүлэх сургалт НТБТ зохион байгуулдаг байх

Анги танхим нь ХӨБ сурахад хүртээмжтэй байх хэрэгтэй

Сурагчдад сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлын сургалт явуулах

ЗГ аливаа бодлого төлөвлөлт гаргахдаа ялгаатай бүлгийн төлөөллүүдийг оролцуулж хамтардаг байх

Хөвгүүд анги ахих тусам сургууль завсардалт нэмэгддэг

Сургууль завсардалсан хүүхдүүдийн тоо мэдээллүүдийг нарийвчлан гаргаж тогтмол хяналт тавьж байх

Хос хэлний хөтөлбөр батлах

Цахим сургалтад шилжихдээ төхөөрөмжийн үр ашиг, урсгал зардлыг сайтар тооцож худалдан авах. Цахим сургалтад багш нарыг бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулах

Б ХУВИЛБАР “САНАЛ НЭГ / САНАЛ НИЙЛЭХГҮЙ БАЙНА” ЗАГВАР

Зорилго: Сургууль завсардалт гэж юу вэ? Ямар шалтгаанаас сургууль завсардалт үүсэж болох вэ? Боловсролын үйл ажиллагааг хэрхэн тасалдалгүй явуулж болох талаар бодлоо хуваалцах зорилготой.

Зорилт: Энэ нь суралцагчдыг аливаа асуудлын талаарх хэд хэдэн үзэл бодлыг өөр өөрсдийн байр сууриа эргэцүүлэн бодоход урамшуулах энгийн арга бөгөөд энэ аргаар сургууль завсардалт гэдгийг сурагчид өөрсдөө тодорхойлж гаргаж ирнэ. Энэ арга нь нарийн төвөгтэй асуудал, олон янзын үзэл бодлыг судлах аргачлал юм.

Анги танхимын бэлтгэл:

Энэхүү дасгал нь орон зай шаарддаг учир та сургуулийн коридорт, гадаа талбай, биеийн тамирын заал зэрэг зай ихтэй газар зохион байгуулах боломжтой. Анги танхимыг дундуур нь 2 хуваан туузан наалт наана (олс ашиглах, шохой хэрэглэх зэрэг байж болно). Суралцагчид өөрсдийн туршлага, үзэл бодлоосоо хамааран багшийг асуулт асуухад шугамын 2 талд гарч зогсоно. Шугамын нэг талд нь ‘Санал нэг’, нөгөө талд нь ‘Санал нийлэхгүй байна’ гэсэн бичиг наасан байна.

Зохион байгуулалт:

Энэхүү дасгал нь хүн бүрт тайван замаар оролцох боломжийг олгох ёстой. Багш сурагчдаас урьдчилж бэлдсэн өгүүлбэрийг уншиж өгөөд “санал нэг” эсвэл “санал нийлэхгүй байна” гэдгээ өөрөө сонгоно. (Хавсралт 2) Сурагчид тухайн өгүүлбэртэй санал нэг бол “санал нэг” хэсэгт, үгүй бол “Санал нийлэхгүй байна” хэсэгт зогсоно. Багш сурагчдыг 2 хэсэг хуваан зогссоны дараа яагаад хэмээн учир шалтгааныг асууж сурагчдыг идэвхтэй яриулна. Сурагчын тоо олон байгаа бол тодорхой тооны сурагчдыг яриулаад, дараагийн асуулт дээр өөр сурагчдыг яриулах зэргээр ээлжилж болно. Тухайлбал, “Манай анги өвөлдөө маш хүйтэн байдаг”. Шугамын нэг талд нь **“Санал нэг”** энэ бол сургууль завсардах шалтгаан гэж үзэж байгаа бол, нөгөө талд нь **“Санал нийлэхгүй байна”** энэ бол сургууль завсардах шалтгаан биш гэж үзээд аль санал нэг байгаа талдаа зогсоно, мөн шугамын дагуу зогсож болох ба энэ нь дундын байр суурь юм.

Чиглүүлэгч багшид өгөх зөвлөмж:



Хүн өөрийн үзэл бодлоо өөрчилж болно, үзэл бодолд зөв эсвэл буруу хариулт байхгүй гэдгийг тайлбарлаарай.



Дараагийн хуудсанд суралцагчдад санаа авч болох кейс санал болгоно. Эдгээрийг та өөрийн хүссэнээр өөрчлөх боломжтой. Гол зорилго нь **сургууль завсардалт зөвхөн хүүхэд сонирхолгүй болсон гэдэг ганц шалтгааны улмаас үүсдэггүй хүүхдээс хамааралгүй олон ялгаатай шалтгааны улмаас сургууль завсардалт үүсдэг** гэдгийг харуулах явдал юм. Мөн нэг дор хэд хэдэн бэрхшээл тулгарах нь хүүхдүүд сургууль завсардахад ихээхэн нөлөөг үзүүлнэ гэдгийг ойлгуулахад чиглэнэ.



Суралцагчид өөрийн үзэл бодлоосоо хамааран шугаман дээрх байр сууриа өөрчилснөөр кейсүүдийн асуудал, үр дагавар, шийдлийг нэг нэгээр нь хэлэлцэн ярилцах, мэтгэлцэх боломж олго.



Сайн дураараа сонгосон газартаа зогсох болсон шалтгаанаа тайлбарлаж, хэрэв хүсвэл бүлгийн бусад гишүүдэд ухуулж, бусад сурагчдийг байр сууриа өөрчлөх боломж олгохыг хүс.



Мөн суралцагчаас нэг нэгээрээ гарч ирээд, нэг мэдэгдлийн хариуд хаана зогсохоо шийдэж яагаад энэ сонголтыг хийснийг тайлбарлахыг хүс.

Эцэст нь дүгнэлтийг чиглүүлж буй багш хийнэ. Зорилго нь “сургууль завсардалт” гэсэн тодорхойлолтын талаар сурагчид нэгдсэн саналд хүрэх явдал юм.

Дүгнэх асуултыг дараах байдлаар асууж болох юм.



Сургууль завсардалтын яг ямар шалтгааныг хүн бүр хүлээн зөвшөөрдөг вэ?



Сургууль завсардалтын өөр ямар ямар шалтгаанууд байж болох вэ?



Нэг сурагчид хэд хэдэн саад бэрхшээлүүд нэг зэрэг тохиолдвол ямар үр нөлөө үзүүлэх вэ?



Эцэст нь, ямар шийдэл байж болох вэ?

Хэрэглэгдэхүүн:

САНАЛ НИЙЛЖ БАЙНА \ САНАЛ НИЙЛЭХГҮЙ БАЙНА

1. Зарим үед хичээл орох багш байхгүй гээд хүүхдүүдийг эрт тараадаг.
2. Манай ангийн нэг хүүхэд хичээлдээ олон хоног ирээгүй тул цагдаад мэдэгдэж орон нутагт хайх ажил эхэлсэн.
3. Засгийн газар сургуулиудын төсвийг нэмээгүй учир манай сургууль сурагчдаас саван вок, анги засвар гэх мэт нэмэлт мөнгө хураадаг.
4. Манай нутагт халдварт өвчин дэгдэж сургуулиуд хаагдсан. Багш хичээлээ цахимаар зааж байгаа ч надад гэртээ хичээлээ хийх боломж байдаггүй. Учир нь интернэттэй холбогдоогүй, бас надад ухаалаг утас байхгүй. Аав ээж хоёр хэлэхдээ над шиг хүүхдүүд гадуур ажил хийж байгаа гэсэн.
5. Манай нутагт гурван жил хангалттай бороо ороогүй. Би эцэг эхдээ туслалж оторт явахын тулд мал маллаж байгаа ч үнэхээр хэцүү. Ихэнх хүүхдүүд гэр бүлдээ туслах хэрэгтэй байгаа учраас сургуульд явахаа больдог.
6. Би жирэмсэн болсон учир багш, сурагчид надтай хүйтэн хөндий харьцах болсон. Би сургуульд явахыг хүсэхгүй байна.
7. Манайх сургуулиас нэхдэг мөнгийг өгч чаддаггүй болохоор багш, сурагчид намайг ялгаварлан харьцаж байгаа юм шиг санагдаад сургуульдаа явах дургүй болсон.
8. Багш нарын хурлын үеэр биднийг маш их загнаж олон цаг зогсоосон.
9. Би айлын ууган хүү учир гэр бүлийнхээ амьжиргааг залгуулах хэрэгтэй, иймд зах дээр тэрэг түрж өдөр хоногийн талхны мөнгөө олдог.
10. Би хурдан морь унадаг, хаврын улсын шалгалтын өдрүүдээр сунгаанд явах хэрэгтэй болдог учир хичээлдээ явж чаддаггүй, энэ нь ч надад амар байдаг.
11. Би Баян-Өлгий аймгаас хот руу шилжиж ирээд сургуульд сурч байгаа, хичээлээ гүйцэд сайн ойлгохгүй болохоор хоцрогдол үүсч байгаа. Монгол хэлээр аялагатай ярьдаг болохоор манай ангийнхан намайг шоолдог.
12. Би айлын том охин хүүхэд, ар гэрийн ажлаа хариуцах үүрэгтэй. Дүү нараа харах хэрэгтэй байдаг болохоор сургуульд явдаггүй.
13. Манай аймагт зуд болоод манайх бүх малаа алдчихсан тул бид хот руу нүүсэн.

14. Би асрамжийн газар амьдардаг. Хичээлдээ явна гэхээс айдас төрдөг. Учир нь манайхаас өгсөн хичээлийн хэрэгсэл чанар муу байдаг болохоор багш нараас эхлээд л намайг сургуульд явж байгаад дургүй байгаа нь мэдрэгддэг. Бүтэн жилийн турш ангийнхандаа ад шоо үзэгдэж явах маш хэцүү санагддаг.


15. Би 70 хувийн сул хараатай, сургуульдаа ирж очиход автобусныхаа дугаарыг харах надад маш хэцүү. Саяхан автомашины осолд ороод сургуульдаа явж чадахгүй байгаа.

16. Би малчин айлын хүүхэд, дотуур байранд аав ээжээсээ олон сар хол маш хэцүү байдаг.

17. Ах бид 2 дундаа нэг дүрэмт хувцастай. Ахынгаа хичээлээс ирэхээр нь би зөрөөд хичээлдээ явдаг учир эхний 1 цаг хоцордог. Байнга хоцроод байхаар сургуулийн захирал дээр дуудагдаж загнуулдаг. Би дундаа нэг дүрэмт хувцастай гэж хэлж чаддаггүй. Ичээд.

18. Манай гэр сургуулиас их хол байдаг. Би нэг талдаа 1 цаг алхаж хичээлдээ явдаг. Учир нь автобус явдаггүй юм. Одоо өвөл болох гэж байгаа учир би их айж байна.

19. Өөр хорооллоос хүүхдүүд манай сургууль дээр ирж биднийг доромжилж, дээрэлхдэг. Энэ байдлыг нийгмийн ажилтандаа хэлсэн ч яаж ч чадахгүй байгаа. Тэднээс болоод сургуульдаа явна гэхээс дургүй хүрч байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ТАНАА

Бид танд **“Найзыг минь сургуульд ОРУУЛ!”** төсөлт аяны хүрээнд захидал бичиж байна. Би аймгийн\хотын сумын\ дүүргийн -р сургуулийн ангийн сурагч.

Миний нэрийг гэдэг.

Дэлхий нийтээрээ хүн бүрт чанартай боловсролыг эзэмшүүлдэг байхын төлөө хамтдаа хичээж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа - 2050” бодлогын баримт бичиг болон Боловсролын ерөнхий хуульд хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх санаачлалыг дэмжин Боловсролын ерөнхий хуулийн 10.2.5 д заасны дагуу ерөнхий боловсролыг 12 жилийн хугацаанд заавал эзэмшихээр заасан байна. Харамсалтай нь миний үеийнхэн янз бүрийн саад бэрхшээлийн улмаас сургуульд суралцах боломжгүй байдгийг бид хичээлээрээ судалж мэдлээ. Хөгжлийн бэрхшээлийн улмаас, дайны улмаас, алслагдсан байрилын улмаас, эдийн засгийн боломжгүйн улмаас, ялгаварлан гадуурхлын улмаас гээд олон шалтгаанаас болж хүүхдүүд сургууль завсардаж, сургуулийн гадна орхигдож байна.

Сурагчид бид дэлхийн өнцөг булан бүрт боловсрол эзэмшиж чадахгүй байгаа найз нөхдөө сургуульд явж, боловсрол эзэмшин, сайн сайхан амьдраасай хэмээн энэхүү төсөлт ажилд оролцсон юм. Хүүхдүүд ямар ч нөхцөл байдалд байгаагаас үл хамааран сургуульд суралцдаг байхын төлөө Монгол Улсын Засгийн Газрыг бэлтгэл ажил хийх, тэдний эрхийг хамгаалах, боловсролд тогтвортой хөрөнгө оруулалт хийх, яаралтай арга хэмжээ авч дэмжлэг үзүүлэхийг хүсч байна.

Таныг манай сургуульд хүрэлцэн ирж бидний боловсруулсан санал, шийдэлтэй танилцах санаачилга гаргавал сургуульд явж чадахгүй байгаа мянга мянган хүүхэд баярлах болно гэдэгт итгэж байна.

Таны хариуг тэсэн ядан хүлээж байна.

Хүндэтгэсэн

Сурагч

***Сургуулийн нэр, шуудангийн хаяг, холбоо барих утас**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭРХЭМ ГИШҮҮН ТАНАА

Бид танд **“Найзыг минь сургуульд ОРУУЛ!”** төсөлт аяны хүрээнд захидал бичиж байна. Би аймгийн\хотын сумын\дүүргийн -р сургуулийн ангийн сурагч.

Миний нэрийг гэдэг.

Дэлхий нийтээрээ хүн бүрт чанартай боловсролыг эзэмшүүлдэг байхын төлөө хамтдаа хичээж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа - 2050” бодлогын баримт бичиг болон Боловсролын ерөнхий хуульд хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх санаачлалыг дэмжин Боловсролын ерөнхий хуулийн 10.2.5 д заасны дагуу ерөнхий боловсролыг 12 жилийн хугацаанд заавал эзэмшихээр заасан байна. Харамсалтай нь миний үеийнхэн янз бүрийн саад бэрхшээлийн улмаас сургуульд суралцах боломжгүй байдгийг бид хичээлээрээ судалж мэдлээ. Хөгжлийн бэрхшээлийн улмаас, дайны улмаас, алслагдсан байрилын улмаас, эдийн засгийн боломжгүйн улмаас, ялгаварлан гадуурхлын улмаас гээд олон шалтгаанаас болж хүүхдүүд сургууль завсардаж, сургуулийн гадна орхигдож байна.

Сурагчид бид дэлхийн өнцөг булан бүрт боловсрол эзэмшиж чадахгүй байгаа найз нөхдөө сургуульд явж, боловсрол эзэмшин, сайн сайхан амьдраасай хэмээн энэхүү төсөлт ажилд оролцсон юм. Хүүхдүүд ямар ч нөхцөл байдалд байгаагаас үл хамааран сургуульд суралцдаг байхын төлөө Монгол Улсын Засгийн Газрыг бэлтгэл ажил хийх, тэдний эрхийг хамгаалах, боловсролд тогтвортой хөрөнгө оруулалт хийх, яаралтай арга хэмжээ авч дэмжлэг үзүүлэхийг хүсч байна.

Таныг манай сургуульд хүрэлцэн ирж бидний боловсруулсан санал, шийдэлтэй танилцах санаачилга гаргавал сургуульд явж чадахгүй байгаа мянга мянган хүүхэд баярлах болно гэдэгт итгэж байна.

Таны хариуг тэсэн ядан хүлээж байна.

Хүндэтгэсэн

Сурагч

***Сургуулийн нэр, шуудангийн хаяг, холбоо барих утас**

НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ХИЙХ АРГАЧЛАЛ




ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛОХ, СААД БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ - СУРАГЧДЫН МАНЛАЙЛЛЫН СОРИЛТУУД.

“Дэлхийн иргэн болоорой!” нь идэвхтэй иргэнийг хэрхэн бэлдэх чиглэлээр багш нарт зориулсан гарын авлага юм. Энэ нь 11-16 насны хүүхдүүдэд зориулагдсан боловч олон үйл ажиллагааг бага эсвэл өсвөр насны хүүхдүүдэд тохируулан өөрчилж болно. Доорх хоёр тоглоомыг нөхцөл байдлаас шалтгаалан

хослуулан эсвэл дангаар нь ашиглаж болно. Тоглоом тоглонгоо сурагчдыг тодорхой асуудлуудад авах ёстой хариу арга хэмжээг тодорхойлох замаар иргэний оролцооны талаар эргэцүүлэн шүүн тунгаахад туслах болно.

1. ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛОХ- БИД ЯМАР БОЛГОХЫГ ХҮСЭЖ БАЙНА

Энэ нь сурагчидад аливаа асуудлыг шийдэхийн тулд хийж болох арга хэмжээг тодорхойлоход нь туслах үйл ажиллагаа юм. Бүлэгт сурагчид үг эсвэл зураг ашиглан доорх схемийн хуулбарыг бөглөнө.



Сурагчид бүлгээрээ “бид юу хийх вэ” төлөвлөгөөгөө **SMART** мөн эсэхийг ярилцах ёстой.

- S** Specific (Тодорхой)
- M** Measurable (Хэмжигдэхүйц)
- A** Achievable (Хэрэгжиж болохуйц)
- R** Realistic (Бодитой)
- T** Time-bound (Цаг хугацаатай)

Хэрэв төлөвлөгөө чинь SMART биш байвал илүү SMART болгон өөрчлөөрэй.

2. СААД БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ - ТООСГО БА АЛХ

Сурагчид SMART аргаар юу хийхээ тохиролцсоны дараа тэдэнд ямар нэг саад бэрхшээл тулгарах болно. Тоосго ба алх нь эдгээр саад бэрхшээлийг тодорхойлж, бэрхшээлийг даван туулахад тусалдаг аргачлал юм.

Том цаасан дээр тоосго зурцгаана.

Амжилтад хүрэх боломжтой жижиг төлөвлөгөө нь хүрч чадахгүй том төлөвлөгөөнөөс дээр

Тоосго бүр сурагчид үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэхэд тулгарч болох саад, бэрхшээлийг илэрхийлнэ. Зарим бэрхшээлүүд ердийн зүйл байж болно. Жишээлбэл: хэн сургуулийн ханыг ашиглах зөвшөөрөл авах вэ? гэх мэт. Харин зарим нь шийдэхэд төвөгтэй асуудал байх болно. Жишээлбэл: хэрхэн танихгүй хүнээ гол илтгэгчээр урих вэ? гэх мэт. Сурагчдын санаанд орсон бүх асуудал тоосгон дээр бичигдэх ёстой, нэг асуудлыг нэг тоосго дээр бичнэ.

Дараа нь цаасаар алх хийнэ, интернэтээс олон төрлийн алхны дүрсүүдээс авч хэрэглээрэй. Алх бүр тоосгыг (саад) нураах боломжтой шийдэл гэж үзээд тохирох тоосготой хамтад байрлуулна. Шийдэл нь саадруу буцаж, өөр аргаар бодох явдал байж болохыг санаарай.

Дуусгасны дараа сурагчид тоосго, алхаа хянаж, шаардлагатай байж болох шинэ арга хэмжээний талаар тохиролцох хэрэгтэй.

Алхам 1 Үйл ажиллагааны төлөвлөгөө бичих – Бодит амьдрал дээр хэрэгжүүлье!

Энэ тоглоом нь сурагчдад хүрч болох нэг зорилго, түүнд хүрэх үйл ажиллагааг төлөвлөх, өөр хоорондоо зөвшилцөх, болзошгүй бэрхшээлийг тодорхойлох, түүнийг даван туулах арга замыг олохын төлөө хамтран ажиллахад тусална. Уг үйл ажиллагааныхаа гол санааг бичин үлдээж, цаашид ашиглах зорилгоор хадгалж авах хэрэгтэй.

Сурагчдын манлайллын дараагийн алхам бол сурагчид санаагаа хэрэгжүүлэхэд **манлайлах** явдал юм. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд багагүй хугацаа шаардаж магад. Сурагчид хамтран ажиллаж, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргаж, дараа нь тодорхой хугацаанд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх, дүгнэх уулзалтуудыг хийх ёстой.

Өөрт байгаа цаг, тулгарч байгаа бэрхшээлүүдийнхээ өмнө шударга бай. Бүх зүйлийг зэрэг хийх боломжгүй. Байгаа нөөцөө үнэлж, хугацаагаа тодорхой болгон гаргасан төлөвлөгөөгөө биелэх боломжтой болгох хэрэгтэйг анхаар.

Доорх логик хүрээ нь сурагчдыг зорилгоо тодорхойлох, зорилгодоо хүрэхийн тулд хийх үйл ажиллагаануудын жагсаалт гаргахад чиглэж үр нөлөөгөө хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох, гаргасан үр дүнгээ бодитоор үнэлэхэд тусална. Үүний тулд дараах зөвлөгөөг дагаарай.



1. Төлөвлөгөөг шаардлагатай бол нарийн зүйлсийг тусгах үүднээс өргөтгөх хэрэгтэй. Жишээлбэл, 'Бид юу хийх гэж байна вэ?' хэсэгт сурагчдын нэрийг даалгаварт хавсаргаж болно.

2. Төлөвлөгөө нь уян хатан байх хэрэгтэй. Болохгүй бол өөрчлөх эрх нь сурагчдад бий. Дээрх **Тоосго ба Алх** үйл ажиллагаа нь сурагчидад саад бэрхшээл, сорилттой тулгарвал тус болно.



Та бүхний боловсруулсан төлөвлөгөө уян хатан байх ёстой, тийм биш бол өөрчлөх хэрэгтэй.

Алхам 2. Уулзалт хийх - “Төслийн эрч хүчийг хадгалах”

Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ сурагчид хэдэн долоо хоног, бүр хэдэн сарын хугацаанд эрч хүчээ хадгалж, ахиц дэвшил гаргахыг шаарддаг. Энэ нь хэцүү байж болно. Насанд хүрэгчид шийдвэр гаргах, үүрэг хариуцлагыг хуваарилах, ахиц дэвшилээ хянахын тулд байнга уулзаж хуралдах хэрэгтэй болдог шүү дээ. Түүнтэй ижил сурагчид багшийн удирддаг хичээлд дассан бөгөөд өмнө нь хэзээ ч “хуралд” оролцож байгаагүй байдаг.

САЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗӨВЛӨГӨӨ

Уулзалт нь зочломтгой, сонирхол татахуйц, үр дүнтэй, ажил хэрэгч байх ёстой. Сурагчдад уулзалтаа сайн зохион байгуулах таван зөвлөгөөг танилцуулж, доорх жагсаалттай санал нийлж байгаа эсэхийг харахыг хүсээрэй. Сурагчид өөрсдөө өөр, илүү сайн санаануудыг санал болгож болно.



1. Сайн чиглүүлэгч. Хурлыг чиглүүлэгч нь хүн бүр ээлжээр хүссэн үедээ үг хэлэх боломжтой, хэлэлцүүлгийг хэн ч давамгайлахгүй байх, хэлэлцэх асуудлын дарааллыг баримталж эсэхэд анхаарах хэрэгтэй болдог. Энэ бол ур чадвар юм. Чиглүүлэгчийн үүргийг ээлжлэн хийх ёстой бөгөөд ингэснээр хүн бүр туршлага хуримтлуулах боломжтой болно. Багш нь шаардлагатай ур чадварыг үлгэрлэх анхны хурлыг даргалж болох боловч чиглүүлэх нь багшийн үүрэг биш гэдгийг санаарай.



2. Найрсаг уур амьсгал. Багийн, хурлын уур амьсгал нь найрсаг, аюулгүй мэдрэмж төрүүлэхүйц байх ёстой. Зарим оролцогчидтой санал нийлэхгүй байж болох ч үргэлж хүндэтгэлтэй хандаарай. Нэгэнт олонхын саналаар шударга шийдвэр гаргасан бол хүн бүр санал нийлэхгүй байсан ч дагах ёстой. Завсарлага авах, хөгжим тавих эсвэл хөнгөн зууш авчрах нь найрсаг уур амьсгалыг бий болгоход үргэлж тусалдаг гэдгийг сана.



3. Зорилгоо тодорхой болгох.

Хамгийн сайн уулзалт бол хүн бүр юунд хүрэхийг хичээж байгаагаа тодорхой мэддэг байх явдал юм. Хэрэв оролцогчид гацсан бол хурлын зорилгыг дахин сануулах хэрэгтэй.



4. Тодорхой хэлэлцэх асуудал. Энэ нь хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг урьдчилж гаргах тухай юм. Ингэснээр хүн бүр хэзээ юу ярилцах ёстойг харах, мэдэх боломжтой болно. Бүх зүйл нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд хэлэлцэх асуудал бүрд тодорхой цаг хугацаа хуваарилах хэрэгтэй. Хурал тохиролцсон цагийн хуваарийн дагуу явагдаж буй эсэхийг шалгах нь чиглүүлэгчийн үүрэг юм.



5. Тодорхой шийдвэрүүд. Хурал бүрд бүлгийн шийдвэр, хүмүүс юу хийхээр тохиролцсон, эцсийн хугацааг бичгээр хөтөлдөг тэмдэглэл хөтлөгч эсвэл “Нарийн бичгийн дарга” байх ёстой. Тэмдэглэл нь хурлын дараа багийн гишүүд рүү илгээгдэх ёстой бөгөөд ингэснээр хүн бүр юу хийх ёстойгоо мэдэж, уулзалтад оролцоогүй бусад хүмүүс мэдээлэлтэй байх болно.

ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ

Хурал зохион байгуулах нь төвөгтэй биш харин хурал хооронд юу тохиолдсон нь. Доорх загварын дагуу хурлын үеэр хэн юу хийхээр болсон, дараагийн хурал болоход хэрэгжилт ямар байгааг мөшгөөрэй.

Хурлын сэдэв

Хугацаа.....

Хуралд оролцсон хүмүүс
(цахимаар оролцсон хүмүүсийг ч бүртгэнэ)

Хуралд оролцож чадаагүй хүмүүс

Сүүлийн уулзалтаар хүмүүс юу хийхээр тохиролцсон талаар эргэн мэдээлнэ үү

Үйл ажиллагааны хөтөлбөр 1

Үйл ажиллагаа

Хөтөлбөр тус бүрд гаргана

Хэн удирдах?
Юу хийх?
Хэзээг хүртэл хийх?
Хэн туслах?
Явал амжилттай болсон гэж үзэх?

Бусад

Үйл ажиллагаа

Чиглүүлэгч оролцогчдоос өөр хэлэх зүйл байгаа эсэхийг асууна.

Хэн удирдах?
Юу хийх?
Хэзээг хүртэл хийх?
Хэн туслах?
Явал амжилттай болсон гэж үзэх?
Дараагийн уулзалтын өдөр, цаг, байршлыг тогтоно

Дараагийн уулзалтын өдөр, цаг, байршлыг тогтоно

Хэрвээ чи дараагийн уулзалтаар үүрэгт ажлаа хийж амжаагүй бол шударга байж, багийн бусад гишүүддээ яагаад хийж чадаагүй талаараа нээлттэй ярилцаж хугацаагаа өөрчлөөрэй. Шинэ хугацаандаа тааруулан амжуулахыг хичээгээрэй.

БОЛОМЖИТ АРГА ХЭМЖЭЭ

Одоо бүлэг зохион байгуулагдсан тул арга хэмжээ авах зарим санааг энд оруулав.

Бүлгээрээ хийж болох зарим үйл ажиллагаа энд байна. Энэ бол бүрэн жагсаалт биш бөгөөд сурагчидыг аль болох бүтээлч байхыг дэмжих хэрэгтэй. Тэд ямар ч төлөвлөгөө гаргасан бай тэдний үйлдлүүд хэрхэн уялдаж, кампанит ажил зохион байгуулах талаар бодох ёстой.

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь дээрх гурван зүйлд нийцсэн байх ёстой

1. Төлөвлөгөөг хийх боломжтой байх ёстой.
2. Бүлэг үүнийг хийхдээ урам зоригтой, хүсэл эрмэлзэлтэй байх ёстой.
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр өөрчлөлт гарах ёстой.

Төлөвлөгөө нь дээр дурдсан зүйлсийн аль нэгийг хангаагүй бол баг үүнийг хянан үзэх шаардлагатай. Алдаа гаргаж, төлөвлөгөөгөө өөрчлөх нь зүгээр. Бүх хүн ингэж л сурдаг.

1. Бусад сурагчдаа зааж, мөн тэдний дэмжлэгийг хүс

Багаараа сургуулийн бусад багш, суралцагчдад кампанит ажлынхаа талаар танилцуулж, тэднээс дэмжлэг хүсээрэй. Үүнийг цугларалт, хичээл эсвэл үдийн цайны лангуу зэрэг арга хэмжээнд хийж болно. Бусад суралцагчид дэмжлэг үзүүлэх эсэх нь сайн дурынх гэдгийг санаарай. Амжилтанд хүрэх дөрвөн зөвлөмж байдаг

- i. Юу ярихаа төлөвлөж шаардлагатай материалуудаа бэлдээрэй- жишээлбэл ППТ, постер, сургалтын үйл ажиллагаа гэх мэт
- ii. Зорилгоо **тодорхой, ойлгоход амар** байхад анхаараарай. Бусдыг

өөрсдийнхөө хийж байгаа кампанит аяныхаа талаар чамаар илүү мэдээлэлтэй байна гэж битгий найдаарай.

- iii. Ярих яриагаа бэлдэж давтаарай.
- iv. Харилцагч хүмүүстээ кампанит аяныг дэмжиж үйлдэл хийхийг уриалаарай- жишээлбэл, УИХ гишүүдэд захидал бичих


2. Бага ангийг татан оролцуулж болно.

Сурагч та бүхэн бага сургуультайгаа холбогдож (бага ангийн багш), кампанит ажлынхаа талаар 2-5р ангийн дүү нартаа танилцуулахыг хүсээрэй. Ингэснээр сурагчид зохион байгуулалтаа сайжруулж, илтгэх чадвараа хөгжүүлээд зогсохгүй бусад сурагчдыг аяндаа хамруулах боломж бүрдэх юм.

3. Бүтээлч байгаарай

Сургуулийн кампанит аяны дэмжихийн тулд бүтээлч байгаарай. Өөрийн гарын ур дүй, зурах чадвараа ашиглан постер болон бусад материалуудаа хэрхэн өнгөлөг, сонирхолтой бусдад үзүүлэх талаараа багаараа ярилцаарай. Жүжигчилсэн тогтолт хийхэд хэн тусалж чадах уу? Багаас хэн сургуулийн Фейсбүүк, Х эсвэл Инстаграм хаягт мэдээлэл бэлтгэж оруулах, эсвэл сургуулийн вебсайтад мэдээ бэлтгэн түгээх ур чадвар байгаа юу? Эдгээр бүх санал болгосон санаануудын нэгэн адил бүлэг төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө багштай тохиролцох ёстойг анхаараарай.

Багш, сурагчид хамтдаа “Асуудлын мод” загвараар сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн асуудлыг шинжилж, шийдэх арга замуудыг ярилцсан билээ. Дараагийн бүтээлч алхам бол бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад чиглэсэн **нөлөөллийн ажил** юм. Энэ нь сурагчдад **иргэний боловсрол** олгох ач холбогдолтой арга.



1. УИХ гишүүнийг сургууль дээрээ урих

УИХ-ын гишүүд, Засгийн газарт аяныг дэмжихийг уриалснаар өөрчлөлтийг арай хурдан хийж болдог. Иймд танай аймаг, дүүргээс нэр дэвшин сонгогдсон, эсвэл улс төрийн намын жагсаалтаар сонгогдсон УИХ-ын гишүүнийг сургууль дээрээ урьж өөрсдийн төсөлт ажлаа танилцуулаарай. УИХ-ын гишүүдийн талаар болон тэдэнтэй хэрхэн холбогдох талаар дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.parliament.mn/cv/?appointmentId=105> сайтаас авах боломжтой.

Сурагчид УИХ-ын гишүүнтэйгээ нүүр тулан уулзах эсвэл түүнд хандан захидал бичих зэрэг нөлөөллийн аргыг хэрэглэснээр ардчилалд суралцаж буй хэрэг юм.



2. Хэвлэл мэдээлэлд хандах

Сурагчид манлайлан нийгмийн өөрчлөлтөд уриалж буй үйл явдал, түүхийг хэвлэл мэдээлэл ихээхэн сонирхдог тул хэвлэлийн мэдээ бэлтгэх, сэтгүүлчидтэй холбоо харилцаа тогтоох, өөрсдийн зохион байгуулж байгаа санаачилга, кампанит ажлаа хэвлэл мэдээллээр түгээх бүрэн боломжтой. Мөн сургуулийнхаа вэбсайт, мэдээллийн товхимол, социал медиа хуудас дээр бичиж болно. Хэвлэлийн мэдээний агуулгадаа өөрсдийнхөө тодорхойлсон асуудал хэрхэн чухал блох, хийж буй арга хэмжээ, уншигчид хэрхэн дэмжлэг үзүүлж болох талаар хэлэх ёстой.



Судалгаа хий

Танай багтай ижил төстэй асуудлаар кампанит ажил явуулж буй байгууллагууд ихэвчлэн тайлан, товч танилцуулга, түүхүүдийг олон нийтэд нийтэлсэн байдаг. Сурагчид эдгээртэй танилцсанаар ойлголтоо сайжруулж, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх явцдаа сурч мэдсэнээ хэрэгжүүлэх боломжтой. Хүмүүс ихэвчлэн өрөөсгөл (prejudice) ойлголттой байдаг тул зарим тоо баримттай байх нь сайн боловч хэн ч мэргэжлийн шинжээч байх албагүй гэдгийг санаарай. Хүсэл тэмүүлэл, сонирхол, тууштай байдал нь илүү чухал шүү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНТЭЙ УУЛЗАХ ЗААВАР

(Багш нарын анхааралд)

Улсын Их хурлын гишүүдэд Төрийн ордонд суугаад хуулийн талаар маргалдахаас өөр олон ажил байдаг. Орон нутгийн аль болох олон сонгогчидтой уулзаж, тэдний санааг зовоож буй асуудлын талаар олж мэдэх, эдгээр асуудлыг УИХ болон олон нийтэд танилцуулах, улс төрийн кампанит ажил явуулах нь тэдний ажлын чухал хэсэг юм. Сургууль бол УИХ-ын гишүүний тойрог доторх чухал талбар. Сургуулийн сурагчид тун удахгүй ирээдүйн сонгогчид болно.

Энэхүү удирдамж нь 18-аас доош насны сурагчид кампанит аян хэрхэн зохион байгуулж буйг харуулж, УИХ-ын гишүүнээ хэрхэн аяндаа татан оролцуулж болохыг бодитоор багш нарт харуулах аргачлал юм.

Доорх зөвлөмж нь багш нарт зориулсан бөгөөд удирдамж зохиогчдын багаас УИХ гишүүдтэй холбоо барих ажилд багш нарыг чиглүүлэх зорилготой.

УУЛЗАХЫН ӨМНӨ

Алхам 1: Сургуулийнхаа байрлах бүсийн тойргоос сонгогдсон УИХ гишүүдийн мэдээллийг олоорой.

2024-2028 оны Улсын Их хурал пропорционал тогтолцоогоор зохион байгуулагдсан сонгуулийн үр дүнд бүрэлдсэн тойргоос болон жагсаалтаар сонгогдсон гишүүд байгааг сана. Тиймээс та Улсын их хурлын алан ёсны вэбсайтаас УИХ-ын гишүүдийн мэдээллийг авах боломжтой.

Улсын их хурлын албан ёсны вэбсайт <https://www.parliament.mn/>

Энэ удаагийн Их хурал 11 байнгын хороотой бөгөөд хороо тус бүр 12-24 гишүүнтэй. Байнгын хороо нь эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг

урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй ажилладаг. Улсын Их Хурлын гишүүн тус бүр 2 байнгын хороонд харьяалагддаг. Бид энд Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын байнгын хорооны гишүүдийн холбоо барих мэдээллийг орууллаа.

<https://www.parliament.mn/cv/?appointmentid=105>

Санах нь: УИХ гишүүд албаны утас, мэйл, шуудангаар захидал хүлээн авах хүсэлтэй байдаг.

Алхам 2: УИХ-ын гишүүдэд сургуульдаа хүрэлцэх ирэх урилга хүргүүлэх

УИХ-ын гишүүдийн мэдээллийг бэлэн болгосноор сургууль дээрээ хүрэлцэн ирэхийг урихад бэлэн боллоо гэсэн үг. Өөрсдийн мессеж, мэйл, захидалыг товч, тодорхой байхад анхаараарай.

Алхам 3: Магадгүй та бүхэн УИХ гишүүдээсээ хариу авахгүй ч байж мэднэ. Энэ нь цаг хугацаа шаардах ажил юм. Чи юу хийх вэ?

УИХ-ын гишүүд маш завгүй. Тэд УИХ-ын хуралдаанаас гадна сонгогдсон тойрог, намын бүлгийн хурал, байнгын хорооны хурал гээд зэрэгцсэн олон ажилтай байдаг. Өдөр бүр 200-300 мессеж хүлээн авдаг гэсэн тооцоо бий. Тиймээс тэд таны илгээсэн захидалтай шууд танилцахгүй байх магадлалтай. Хэрэв хэдэн хоногийн турш хариу ирүүлэхгүй байвал тэдэн рүү залгах, захидал авсан эсэхийг лавлан асууж болно.

Хэрэв УИХ гишүүн танай сургууль дээр ирэх боломжгүй байвал чи дараах зүйлсийг хийж чадах уу?

1. УИХ-ын гишүүнтэйгээ цаг товлон уулзах
2. УИХ-ын гишүүндээ кампанит аянаа тайлбарлаж, арга хэмжээ авахыг уриалж бичиж болох юм.

Алхам 4: Уулзалтад бэлтгэх

Уулзалтандаа бэлдэх маш чухал. Гэхдээ залуу хүмүүс сандрах хэрэг байхгүй. УИХ-ын гишүүд чамайг энэ ажлынхаа төлөө ямар их урам зоригтой байгааг, юу хийж байгааг, УИХ-ын гишүүдэд юуг уриалж байгааг л мэдэхэд хангалттай.

Мөн УИХ-ын гишүүдээс суралцах боломж.

УИХ-ын гишүүн сурагчдыг бодлогын талаар мэддэг гэж боддоггүй байж мэднэ. Маш олон УИХ-ын гишүүд өөрсдөө мэргэжилтэн биш байдаг. Мөн тэд таны зохион байгуулж байгаа кампанит аяны зорилго, та бүхний танилцуулж байгаа улс төрийн үзэл бодолтой санал нийлэх шаардлагагүй.

Харин сурагчид УИХ-ын гишүүнд өөрсдийн хэрэгжүүлсэн төсөлт ажил, нөлөөллийн ажилд хэр сэтгэлтэй байгаагаа ойлгуулах чухал. Энэ асуудалд УИХ-ын гишүүн ямар байр суурьтай байгаагаас үл хамааран энэ нь ГАЙХАЛТАЙ байх болно.

Сурагчдыг кампанит ажилд нь бэлтгэхэд туслах таван зөвлөгөө

Судал	УИХ гишүүдийнхээ талаар, баримталдаг үзэл санааг судал
Төлөвлө	Хэн, хэн юу хэлэхээ төлөвлө
Давт	Багш УИХ-ын гишүүний дүрд орж тоглон өөр өөрсдийнхөө бэлдсэн сэдвийг танилцуулж болно. Хаана үгээ зогсоох, хаашаа харах зэргээ урьдчилж бэлдэх хэрэгтэй. Илтгэлээ аль болох үзэмжтэй, дурсагдахуйц болгохыг зорь.
Сонс	Сурагчид ихэнх зүйлсийг ярихаар төлөвлөөрэй. Гэхдээ УИХ-ын гишүүнийг уулзалтын 3-ны 1-т яриулахаар төлөвлөөрэй. (10 минут)
Бич	Сүүлийн 5 минутыг зураг дарахад тооцоорой. УИХ-ын гишүүн чинь зургаа ашиглахыг зөвшөөрөх эсэхийг урьдчилж асуугаарай.

УУЛЗАЛТЫН ТУРШИД АНХААРАХ ЗҮЙЛС.

Алхам 5. ППТ -ээ УИХ-ын гишүүндээ танилцуулаад асуултад хариулна.

УИХ-ын гишүүнийг сургуулийн үүднээс тосож аваад уулзалтын өрөө рүү чиглүүлэх хэн нэгнийг урьдчилж томилно. УИХ гишүүд хоцорч магадгүй гэж тооцоорой, яасан ч байсан хүрч ирэхэд нь бэлэн байж байх ёстой.

УИХ-ын гишүүнээ танилцуулаад сурагчдыг ППТ-ээ танилцуулахыг уриарай. Хэлэлцүүлэгт аль болох ойртуулж, УИХ-ын гишүүн гэх мэтээр үг хэлэхээр төлөвлөсөн бүх хүнд шударгаар саналаа хэлэх боломжийг олгохыг зорь.

УИХ-ын гишүүнд үйлдэл хийхийг хүсэхээ мартав. Гол зорилго нь танай кампанит ажлын цар хүрээг УИХ, Засгийн газрын түвшинд хүртэл өргөн хүрээнд авах үзэх нь чухал. Доор УИХ-ын гишүүдээс хийхийг хүсэх боломжтой ажлуудыг орууллаа.

- Уулзалтын талаар социал медиад бичих,
- Сурагчдын өрнүүлж буй аяныг дэмжиж байгаагаа олон нийтэд түгээх,
- Сургуулийнхаа цахим хуудсыг болон <https://www.facebook.com/AFEMNG> таглахыг хүсээрэй.
- #Найзыг_минь_сургууль_оруул! Хаштаг хэрэглэхийг санал болго.
- Кампанит аяны агуулгын талаар Боловсролын сайд, Засгийн газрын гишүүнээс асуулт асуугаарай.

Алхам 6. Сэтгэгдэл төрүүлээрэй

УИХ-ын гишүүд нэг өдөрт чамтай адил олон хүнтэй уулзаж байгаа. Чи харин ямар сэтгэгдэл үлдээж чадах вэ?

Ихэнх кампанит ажил нь бүтээлч байх, нүдээр харуулах боломжийг олгодог. Тиймээс сурагчид уулзалтынхаа хажуугаар

хэрхэн бүтээлч нөлөө үзүүлэх талаар бодох хэрэгтэй. Жишээлбэл, тэд жүжиг, хөгжим, кино эсвэл гэрэл зураг ашиглаж болно. Боломжит хамгийн хүчирхэг, үнэмшилтэй баримт, аргуудыг ашиглаж, уулзалтыг мартагдашгүй болгохыг зорь. Мөн сурагчид өөрсдийн захиасыг хүргэхэд хэр их цаг хугацаа шаардагдахтай уялдуулан төлөвлөх хэрэгтэй.

Сурагчид юу ч хийсэн хүчтэй **зөрөг** уур амьсгал, мессаж өгөхөд анхаар!, сөрөг дарамталсан байх ёсгүй.

Алхам 7. Юу болсныг бичиж үлдээ.

УИХ-ын гишүүнийхээ амлалтын тэмдэглэлийг хөтөл, зураг дарж баримтжуул. Гэхдээ сургуулийнхаа зөвшөөрөл, хүүхэд хамгааллын бодлогыг дагаж мөрдөхөө үргэлж санаарай. Үүнд УИХ-ын гишүүн орно.

УИХ-ын гишүүнийхээ хэлсэн үг, амлалтын талаар тэмдэглэл хөтлөх, мөн зураг авах бичлэг хийх сурагчийг томилоорой.

Гэрэл зургууд нь уулзалтын тухай мэдээллийг олоннийтэд түгээхэд тусалж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хуваалцах боломжтой. **#Найзыг_минь_сургууль_оруул!** хаштаг ашиглахаа бүү мартаарай. Хэвлэлийн мэдээ бичих нь таны түүхийг орон нутгийн телевиз, сонинд гаргахад тусална.

18-аас доош насны сурагчдыг харуулсан зургууд нь танай сургуулийн бодлогод заасны дагуу эцэг эхийн зөвшөөрөлтэй байх ёстойг анхаараарай УИХ-ын гишүүд өөрсдийн олон нийтийн сүлжээнд идэвхтэй байдаг. Иймд тэд танай сургуулийн зөвшөөрлийн бодлогыг дагаж мөрдөж байгаа эсэхийг нягтлаарай. Эцэст нь хэлэхэд, хүн бүрийн зөвшөөрөлгүйгээр цахим уулзалтыг бичиж болохгүй. Дэлгэцийн зураг авбал зүгээр байх болно.

УУЛЗАЛТЫН ДАРАА ЯАХ ВЭ?

Алхам 8. Холбоотой бай

Танай УИХ-ын гишүүн танай сургуулиас явснаар бүх зүйл дуусаагүй шүү. УИХ-ын гишүүнтэйгээ харилцаа тогтоохыг зорь, ингэснээр та бүхний кампанит ажлын тогтвортой байдалд тустай.

Сурагчид дараа нь УИХ-ын гишүүнд захидал бичиж, уулзалт хийсэнд талархаж, уулзахдаа амласан амлалтыг нь сануулах хэрэгтэй. Таны УИХ-ын гишүүн ихэвчлэн вэбсайт эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр контент нийтлэхийг хүсдэг тул та авсан зургаа илгээж болно (эцэг эхийн зөвшөөрөл авсан эсэхээ шалгана уу) УИХ-ын гишүүн сурагчидтай санал нийлж байгаа эсэхээс үл хамааран баярлалаа гэж хэлэхдээ эелдэг байгаарай.

УИХ-ын гишүүнийхээ олон нийтийн хаягийг дагаж УИХ-д та бүхний кампанит ажлыг дэмжиж байгаа эсэхийг шалгаарай. УИХ-

ын гишүүнтэйгээ цаашид харилцаа холбоо тогтоож, тэдэнтэй байнга холбоотой байхыг зорь.

Алхам 9. Дэлхий даяар түгээ!

Уулзалтаа хийсэн даруйдаа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж уулзалтынхаа цар хүрээг өргөжүүлээрэй. Хэвлэл мэдээллийн байгууллага руу явуулах хэвлэлийн мэдээний загварыг ХАВСРАЛТ-аас хараарай. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага сургуулиас амжилтын түүх авахдаа баяртай байдаг. Зурагнуудаасаа хавсаргаарай. Сүүлийн үеийн утсаар хөндлөнгөөр нь дарсан зурагнууд байвал зүгээр. Сургуулийнхаа цахим хаяг, социал медиа хаягийг хэвлэлийн мэдээндээ оруулаарай. Уулзалтынхаа тухай, энэ ажилд хамтран ажилласан байгууллагуудаа дурдахаа мартав аа!



ХЭВЛЭЛИЙН БАГЦ БОЛОВСРУУЛЖ ТҮГЭЭ!

Хэрвээ танай сургууль **Найзыг минь сургуульд ОРУУЛ!** кампанит аян өрнүүлж байгаа бол олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээхээ мартав аа. Ингэснээс аяныхаа мессеж хүрэх цар хүрээг өргөтгөж мөн өөрсдийнхөө хийж байгаа ажлаа нийтэд таниулах боломжтой болно.

Доор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрсдийн аянд хэрхэн татан оролцуулах санааг өгч байна. Сошиал медиад мэдээллээ оруулахдаа @sendmyfriend, #let-

myfriendslearn, #Найзыг_минь_сургууль_оруул! гэсэн хаштагтайгаар мэдээллүүдээ оруулаарай. Сошиал медиад мэдээллээ оруулахдаа үйл ажиллагааны зураг, ангийн ажлын зургуудаа давхар оруулснаар хүн бүр та нарын чухам юу хийж байгааг мэдэх болно шүү дээ.

УИХ-ын гишүүдийн цахим хаягийг олоод багийн ажлын зургуудаа постолж тэдэнтэй холбогдоорой.

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭГ ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Алхам 1. орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоо барих мэдээллийг олоорой. Сургуульд чинь магадгүй зарим мэдээллийн байгууллагатай холбоо барих утасны жагсаалт байгаа байх эсвэл интернэтээс хайхад олдох болно. Сонин, сэтгүүл, ТВ, радио, вэбсайтууд байж болно.

Алхам 2. Доор загвараар өгсөн хэвлэлийн мэдээг шууд хуулаад эсвэл зарим өөрчлөлт хийгээд ашиглаж болно. Мэдээллийн газар руу шууд мэйлээр илгээж болох бөгөөд редакторт мэдээг уншиж хянах 1-2 долоо хоногийн хугацаа олгоорой. Хэвлэлийн газрууд зөвхөн маш чанартай зураг ашигладаг гэдгийг сана. Зураг чинь хөндлөнгөөр дарагдсан байх ёстой шүү.

Алхам 3. Мэдээгээ явуулчихаад тухайн газар руугаа холбогдож мэйлийг чинь хүлээн авсан эсэхийг нягтлаарай. Хэрэв аваагүй байвал дахиад явуулаарай.

Алхам 4. Сайн зураг авах боломж нь хийсэн бүтээлээ сургуулийн хананд гаргах эсвэл УИХ-ын гишүүд ирж уулзах үе байж болох юм. Сайн, чанартай зураг дарахаа битгий мартаарай учир нь мэдээллийн байгууллагууд ирж амжихгүй ч гэсэн чанартай сайн зурагтай хамт хэвлэлийн мэдээ явуулбал дараа нь нийтэлж болдог. Танай сургуулийн хэн нь хамгийн шилдэг зурагчин бэ? гэдгийг олж мэдэх боломж ч байж мэднэ.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД РУУ ЯВУУЛАХ ЗАГВАР

[х УИХ-ын гишүүн] дэлхийн хэмжээнд хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг дэмжих хүсэл эрмэлзэлтэй сурагчдын кампанит ажилтай танилцахаар [х аймгийн\сумын\дүүргийн] [х] сургуульд зочиллоо.

[х УИХ-ын гишүүн] Монгол Улсын засгийн газраас нөхцөл байдлаар үл хамаарах ямар ч үед хүүхэд бүрийн сурч боловсрох эрхийг хамгаалахыг уриалж буй сурагчдыг сонсохоор [х өдөр х цаг] өдөр [х сургуулийн дугаар\нэр] сургуульд иржээ.

[х] сургуулийн сурагчид маш бүтээлчээр, Монгол улс даяар “Найзыг минь сургуульд ОРУУЛ!” гэж уриалж байгаа мянга мянган сурагчидтай нэгдэж байна. “Найзыг минь сургуульд ОРУУЛ!” нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа бүх хүүхдэд чанартай боловсрол олгохыг уриалж, сурагчид, улс төрчид, багш нар, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгслийг нэгдэхийг уриалж байгаа юм.

Сурагчид нөхцөл байдлаас үл хамааран ямар ч үед хүүхдүүдийн сурч боловсрохыг баталгаажуулахын тулд **БЭЛТГЭ, ХАМГААЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ҮЙЛДЭЛ ХИЙ** хүрээнд Монгол Улсын Засгийн Газраас шийдвэртэй арга хэмжээ авахыг уриалж байна. Сурагчид Монгол Улсын Засгийн газраас хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй боловсролын тогтолцоог, сурч чадахгүй байгаа сурагчдын сурч боловсрох эрхийг **хамгаалах, хангах, хөрөнгө оруулалт хийхэд дэмжлэг үзүүлэх** чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг тусгасан болно.

Жил бүр “Найзыг минь сургуульд ОРУУЛ!” нь дэлхий даяар 250,000 залуусыг цуглуулж, дэлхий даяарх найз нөхдийнхөө боловсролын төлөө кампанит ажил өрнүүлдэг. Энэ аяны хүрээнд сурагчид өөрсдөө асуудал, шийдлээ тодорхойлж Засгийн газрыг тухайн асуудлыг шийдэхийг уриалж нөлөөллийн ажил өрнүүлдэг бөгөөд багш нарыг ангидаа кампанит ажил явуулахад шаардлагатай бүх зүйлийг хангаж, сурагчдын дуу хоолойг УИХ-ын гишүүдэд нь сонсгож, найз нөхдийнхөө сурч боловсрох эрхийг хангуулах талаар тавьсан шаардлагыг нь биелүүлэхийг уриалдаг.

[х УИХ-ын гишүүн] тогтвортой хөгжлийн 4-р зорилтыг хэрэгжүүлэхийн тулд боловсролыг нэн тэргүүнд тавих шаардлагатай байгааг онцлон тэмдэглэхийн тулд Монгол улсын засгийн газраас арга хэмжээ авахыг уриалж буй сурагчдаас сонсохоор [х date at x time] өдөр [х school] сургуульд зочилон очиж байна. Энэхүү аяныг Монгол улс даяар сургуульд өрнүүлж байна.

[х сургуулийн] [Багшийн нэрийг оруулна уу]: [Хүүхдийнхээ талаар юу хэлэхийг хүсч байгаагаа оруулна уу, жишээ нь... “Х анги/бүх сургууль Тэд нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд ямар нэгэн зүйл хийхийг эрмэлздэг.”

[УИХ-ын гишүүн орж ирэхэд танай сургууль ямар ажил хийсэн/хийх талаар бичнэ үү, жишээ нь...] “УИХ-ын гишүүдийн анхаарлыг татахын тулд хүүхдүүд Тэд асуултуудаа х УИХ-ын гишүүнд өгч, мессежийг Засгийн газарт хүргэж тэднээс асуухыг хүслээ.]”

